

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Донорын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Донороос эс, эд, эрхтэн авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах журам”-ыг нэгдүгээр, “Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохион байгуулах эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний загвар”-ыг хоёрдугаар, “Амьд донорын зөвшөөрлийн хуудас”-ыг гуравдугаар, “Тархины үхлийг шинжлэн бүртгэх маягт”-ыг дөрөвдүгээр, “Амьгүй донорын гэр бүлийн гишүүний зөвшөөрлийн хуудас”-ыг тавдугаар, “Тархины үхэлтэй донороос эс, эд, эрхтэн авсан болон хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл хөтлөх маягт”-ыг зургаадугаар, “Реципиентийн зөвшөөрлийн хуудас”-ыг долоодугаар, “Амьгүй донор болсон тухай тодорхойлолт”-ыг наймдугаар, “Амьгүй донорын цогцсыг гэр бүлд хүлээлгэн өгсөн тэмдэглэл хөтлөх маягт”-ыг есдүгээр, “Осол, гэмтлийн улмаас тархины үхэлд хүрсэн амьгүй донороос эс, эд, эрхтэн авсан болон хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл хөтлөх маягт”-ыг аравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар /М.Наранпүрэв/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /М.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга/захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар /М.Наранпүрэв/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/198 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ж.ЧИНБҮРЭН

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2023 ОНЫ “ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” А/198 ДУГААР ТУШААЛЫН ШИНЭЧИЛСЭН ЖУРМЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Журам шинэчлэн батлах, үндэслэл, шаардлага:

Эрүүл мэндийн сайдын 2023 оны “Журам батлах тухай” А/198 дугаар тушаалаар “Донороос эс, эд, эрхтэн авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах журам”, “Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг хамтран зохион байгуулах эрүүл мэндийн байгууллагатай хийх гэрээний загвар” “Амьд донорын зөвшөөрлийн хуудас”, “Тархины үхлийг шинжлэн бүртгэх маягт” “Амьгүй донорын гэр бүлийн гишүүний зөвшөөрлийн хуудас”, “Тархины үхэлтэй донороос эс, эд, эрхтэн авсан тухай тэмдэглэл хөтлөх маягт”, “Реципиентийн зөвшөөрлийн хуудас”, “Амьгүй донорын тодорхойлолтын маягт” тус тус батлагдсан.

Тус журам батлагдсанаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба, УНТЭ-ийн бөөр, элэг, шөрмөс, яс шилжүүлэн суулгах баг, ХСҮТ-ийн элэг шилжүүлэн суулгах баг, ГССҮТ-ийн шөрмөс, яс шилжүүлэн суулгах баг, УНТЭ, УХТЭ, УГТЭ, ГССҮТ, Өвөрхангай БОЭТ-ийн тархины үхэл тодорхойлох баг гарын үсэг зурж “Хамтран ажиллах гэрээ” байгуулсан. Тус гэрээ байгуулагдсанаар Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгаж буй эрүүл мэндийн байгууллага, тархины үхэлтэй донор илрүүлж буй эрүүл мэндийн байгууллага болон ЭМХТ-ийн Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба нар хамтран ажиллах боломж бүрдсэн. 2025 оны байдлаар 22 эрүүл мэндийн байгууллагад “Тархины үхэл тодорхойлох баг” байгуулан, мэргэжил арга зүйгээр ханган хамтран ажиллаж байна.

Ингэснээр 2025 оны 10 дугаар сарын байдлаар нийт 278 тархины үхэлтэй боломжит донор илрүүлэн, 72 боломжит донорын гэр бүлтэй донор болох хүсэлтийг тавих уулзалтыг тус алба нь зохион байгуулан 37 гэр бүлээс зөвшөөрөл авч 31 бодит донороос 45 хүнд бөөр, 27 хүнд элэг, 170 гаруй хүнд шөрмөс шилжүүлэн суулгах эмчилгээ хийгдэж 72 хүний амь нас аварч, 170 гаруй хүний амьдралын чанарыг дээшлүүлсэн байна.

2018 оноос 2025 он хүртэл хугацаанд гэрээ, журам, маягтууд үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг хангаж ирсэн боловч практикт гарч буй зарим асуудлуудыг журамд тусгах зайлшгүй шаардлагатай байна. Тухайлбал амьгүй донорын гэр бүлтэй уулзаж донор болгох хүсэлт тавих, тайлбарлах, зөвшөөрсөн тохиолдолд аль аль эд, эрхтнийг зөвшөөрсөн эсэх, амьгүй донороос эд, эрхтэн авах мэс заслын хяналтыг хэрхэн хийх, дүрсжүүлэн баталгаажуулах, цогцсыг гэр бүлд

хэрхэн хүлээлгэн өгөх үйл ажиллагааг илүү нарийн тусгах шаардлагатай байна. Мөн осол, гэмтлийн улмаас тархины үхэлд хүрсэн донор гарсан тохиолдолд хэрхэн ажиллах талаар тусгах зайлшгүй шаардлагатай байна.

Хоёр. Жагсаалт, журам боловсруулах хүрээнд хийсэн гол ажлууд:

Журмыг шинэчлэх хүрээнд УНТЭ, УХТЭ, УГТЭ, ГССҮТ, ЭХЭМҮТ, ХСҮТ-ээс цахимаар саналыг авсан.

Шинэчилсэн журмын төсөлд “Амьд донорын зөвшөөрлийн хуудас”, “Амьгүй донорын гэр бүлийн гишүүний зөвшөөрлийн хуудас”, “Тархины үхэлтэй донороос эс, эд, эрхтэн авсан тухай тэмдэглэл хөтлөх маягт” зэргийг шинэчлэн боловсруулан, “Амьгүй донорын цогцсыг гэр бүлд хүлээлгэн өгсөн тэмдэглэл”, “Осол, гэмтлийн улмаас тархины үхэлд хүрсэн амьгүй донороос эс, эд, эрхтэн авсан болон хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл хөтлөх маягт” зэргийг шинэчлэн боловсруулсан.

Гурав. Хүрэх үр дүн:

Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож буй эрүүл мэндийн байгууллага, Донор эмнэлэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба хамтран ажиллах боломж бүрдэнэ. Амьгүй донорын гэр бүлд оршуулгын тэтгэмж олгоход шаардагдах бичиг баримтын эрх зүйн орчин бүрдэнэ.

ДОНОРООС ЭС, ЭД, ЭРХТЭН АВАХ, ШИНЖЛЭХ, БОЛОВСРУУЛАХ, ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ, УСТГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцогч мэргэжлийн баг, эрүүл мэндийн байгууллага, Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба (цаашид Зохицуулах алба гэх) хамтран амьд болон амьгүй донорын эс, эд, эрхтэн авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү үйл ажиллагаанд үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол харгалзахгүйгээр адил тэгш, үнэн зөв, шударга байх зарчмыг баримтална.

Хоёр. Амьгүй донор илрүүлэх, тандан судлах үйл ажиллагааны зохицуулалт

2.1. Амьгүй донор илрүүлж буй эрүүл мэндийн байгууллага (цаашид Донор эрүүл мэндийн байгууллага гэх)-ын тасгийн эрхлэгч, эмчлэгч эмч тухайн эмчлүүлэгчийг тархины үхэлд хүрсэн байх магадлалтай гэж үзсэн тохиолдолд тархины үхэл тодорхойлох баг (цаашид ТҮТБ гэх)-т мэдээлэл өгнө.

2.2. Донор эрүүл мэндийн байгууллагын ТҮТБ нь боломжит донорын тархины үхлийг бодит үзлэг, сорил, багажийн шинжилгээгээр оношилж, дүгнэлт гаргана.

2.3. Донор эрүүл мэндийн байгууллагын ТҮТБ-ийн ахлагч тархины үхэл тодорхойлогдсон донорыг Зохицуулах албанд мэдээлэн Нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэнэ.

2.4. Донор эрүүл мэндийн байгууллага нь донорын амин чухал эрхтнүүдийг дэмжих эрчимт эмчилгээг үргэлжлүүлнэ.

2.5. Боломжит донор тухайн эмнэлэгт 7 хоногоос дээш хугацаагаар сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээ хийгдсэн тохиолдолд амин чухал эрхтнүүдийн үйл ажиллагаа хэвийн байгаа эсэхийг шинжилгээгээр тодруулж, донорын шалгуур хангах эсэхийг Зохицуулах алба болон шилжүүлэн суулгах баг хамтран шийдвэрлэнэ.

2.6. Дараах тохиолдолд амьгүй донорын шаардлагыг хангаагүй гэж үзнэ.
Үүнд:

2.6.1. 75 ба түүнээс дээш настай;

- 2.6.2. Цусны эргэлт тогтвортой бус артерийн даралтыг хэвийн болгохын тулд даралт зохицуулах болон бусад эмийг их хэмжээгээр хэрэглэсэн;
- 2.6.3. Архи, мансууруулах бодис, эмийн хамааралтай;
- 2.6.4. Биохимийн шинжилгээнд элэгний үйл ажиллагааны үзүүлэлт алдагдсан, эдийн шинжилгээнд өөхжилт 50%-иас их байвал;
- 2.6.5. Вирусийн болон нянгийн идэвхтэй халдвартай;
- 2.6.6. Хорт хавдартай болох нь оношлогдсон;
- 2.6.7. Зүрх нь зогсож амьдралын чухал эрхтэн эргэшгүй өөрчлөлтөд орсон;
- 2.6.8. Жирэмсэн эх.

2.7. Осол, гэмтлийн улмаас тархины үхэлд хүрсэн тохиолдолд энэхүү журмын 7.2, 7.3 дахь заалтыг мөрдлөг болгон ажиллана.

Гурав. Донор эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны зохицуулалт

3.1. ТҮТБ-ийг Донор эрүүл мэндийн байгууллагын дарга/захирлын тушаалаар томилно.

3.2. ТҮТБ-ийн ахлагч нь Донор эрүүл мэндийн байгууллагын эмнэлзүй эрхэлсэн дэд захирал байна.

3.3. ТҮТБ-ийн нарийн бичгийн дарга нь Донор эрүүл мэндийн байгууллагын Чанарын менежер байх бөгөөд тархины үхэлтэй донорыг тухай бүр Зохицуулах албанд мэдээлнэ.

3.4. ТҮТБ-ийн гишүүн тухайн мэргэшлээрээ 8-аас дээш жил тасралтгүй ажилласан, ахлах ба түүнээс дээш зэрэгтэй, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргаагүй эмнэлгийн мэргэжилтэн байна.

3.5. Энэхүү журмын 3.3-т заасан эмнэлгийн мэргэжилтнийг эзгүй үед тус гишүүний ажлыг тухайн чиглэлээр мэргэшлээрээ 8-аас дээш жил ажилласан туршлага бүхий эмч Захирлын томилсноор орлон ажиллана.

3.6. ТҮТБ нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- 3.6.1. Багийн ахлагч (Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал)
- 3.6.2. Багийн нарийн бичгийн дарга (Чанарын менежер)
- 3.6.3. Багийн гишүүд:
 - 3.6.3.1. Эрчимт эмчилгээ судлалын эмч;
 - 3.6.3.2. Мэдрэл судлалын эмч;
 - 3.6.3.3. Чих, хамар, хоолой судлалын эмч;
 - 3.6.3.4. Нүд судлалын эмч;
 - 3.6.3.5. Донорын эмчлэгч эмч;
 - 3.6.3.6. Мэдрэлийн мэс заслын эмч /шаардлагатай тохиолдолд/;
 - 3.6.3.7. Дүрс оношилгоо судлалын эмч /шаардлагатай тохиолдолд/
 - 3.6.3.8. Эмнэл зүйн эмгэг судлалын эмч /шаардлагатай тохиолдолд/ нар байна.

3.7. Багийн ахлагч нь боломжит донорын тухай мэдээлэл авсан даруйд багийн хурлыг зарлан хуралдуулж, хамтарсан үзлэг хийж, донорын эрүүл мэндийн байдал, холбогдох шинжилгээг үндэслэн ТҮТБ хамтран тархины үхэлд хүрсэн эсэхэд дүгнэлт гаргана.

3.8. Тухайн эрүүл мэндийн байгууллагын Чанар, аюулгүй байдлын нэгж нь боломжит донорын амь насыг аврахаар хийгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дүгнэлт гаргаж, энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Тархины үхлийг шинжлэн бүртгэх” маягтад тэмдэглэнэ.

3.9. Эмчлэгч эмч тархины үхэл тогтоох үзлэгийн өмнө удаан хугацаагаар ухаангүйдэх, амьсгал зогсох, гадны шалтгаан байгаа эсэхийг ТҮТБ-т танилцуулна.

3.10. ТҮТБ нь тархины үхлийн эмнэл зүйн шалгуурын дагуу тархины үхэлтэй эсэхийг тодорхойлж багийн ахлагч нь энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Тархины үхлийг шинжлэн бүртгэх” маягтыг бөглөн, гарын үсэг зурж баталгаажуулна.

3.11. ТҮТБ нь гадны шалтгаан ба эмийн аргаар халуун бууруулаагүй, нойрсуулах, тайвшруулах, булчин сулруулах эмийн нөлөө, хордлого үгүйг тогтоосны дараа тархины үхлийг шалгах сорилуудыг хийж гүйцэтгэнэ.

3.12. ТҮТБ нь бичгээр тайлбар хийх шаардлагатай хэсгүүдийг нэмэлт хуудсанд бичиж багийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

3.13. Тухайн эмчлүүлэгчийн тархины үхэл тодорхойлох үзлэг, сорил, багажийн шинжилгээний үр дүн эргэлзээтэй тохиолдолд тархины үхэлд хүрээгүй гэж үзэх бөгөөд цаашид эмчилгээг үргэлжлүүлнэ.

3.14. ТҮТБ нь тархины үхэл нь тогтоогдсоноос хойш 3-6 цагийн дараа давтан үзэж, оношийг баталгаажуулна.

3.15. Тухайн эмчлүүлэгчийн бодит байдал болон тархины үхэлд хүрсэн талаарх мэдээллийг ТҮТБ-ийн ахлагч, тасгийн эрхлэгч, эмчлэгч эмчийн хамт боломжит донорын гэр бүлтэй уулзаж танилцуулна.

3.16. ТҮТБ-ийн ахлагч нь нэн даруй тархины үхэлтэй боломжит донорын мэдээллийг Зохицуулах албанд мэдэгдэнэ.

3.17. Донор эрүүл мэндийн байгууллага нь амьгүй буюу тархины үхэлтэй донорыг илрүүлэх, оношлох, эмчлэх, эрхтэн хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах нөхцөл бололцоог ханган ажиллана.

3.18. Донор эрүүл мэндийн байгууллага нь амьгүй буюу тархины үхэлтэй донороос эс, эд, эрхтэн авах мэс засал хийх нөхцөлийг хангана.

3.19. Энэ журмын 3.18-д заасан мэс засал хийх боломжгүй тохиолдолд энэ журмын 8.1 дэх заалтыг баримтлан ажиллана.

Дөрөв. Тархины үхлийн эмнэл зүйн шалгуур

Тархины үхлийг дараах шалгуураар тодорхойлно.

4.1. Тархины баганын рефлексүүдийг дараах сорилуудаар шалгана.

4.1.1. Хүүхэн харааны сорил: Хүүхэн хараа нэгэн хэмжээнд хэвшиж, тод гэрэл тусгахад урвал(өргөсөхгүй, нарийсахгүй)-гүй байна;

4.1.2. Эвэрлэгийн рефлекс: Нүдний эвэрлэгт ариун бөмбөлгөөр зөөлөн хүрэлцэхэд зовхи хөдлөхгүй байна;

4.1.3. Тэнцвэр-нүдний рефлекс: Чихний гадна 2 сувагт хүйтэн ус 2 мл-ийг урсгаж хийхэд нүд хэлбийх, чичрэх хөдөлгөөн гарахгүй байна; (Сорилыг чихний хэнгэргийн бүтэн эсэхийг шалгасны дараа 2 чихэнд ээлжлэн хийнэ)

4.1.4. Нүд, тархины рефлекс: Толгойг хажуу тийш цочмог эргүүлэхэд нүдний харц толгойн хамт (хүүхэлдэйн нүд) (энэ сорилыг хүзүү гэмтсэн хүнд хийж болохгүй) хөдөлнө;

4.1.5. Залгиур, амьсгалын доод замын рефлекс: Ам хамраар хаймсуур тавих, гуурсаар соруулах үед хөдлөхгүй, ханиахгүй байна;

4.1.6. Хүчтэй өвтгөх цочролын хариу урвал: Нүдний ухархайн дээд ирмэг, уруулын дээр хоншоорын цэг, хумсны толион дээр хүчтэй дарахад ямар нэг хариу урвал илрэхгүй байна.

4.2. Тархины баганын рефлексийн сорилуудад ямар нэг цочролгүй бол амьсгал зогссоныг шалгах (апноэ) сорил хийнэ. Апноэ сорилыг хийхдээ:

4.2.1. Зохиомол амьсгалын аппаратаар 100 хувийн хүчилтөрөгчөөр 10-15 минут амьсгалуулна.

4.2.2. Дараа нь аппаратыг салгаж гуурсаар 1 минутад 4-5 литр хүчилтөрөгч өгч ажиглана. Энэ сорилыг 10 минут хийхэд цусанд хүчилтөрөгчийн дутагдал болохгүй харин нүүрсхүчлийн хэмжээ (PaCO_2) 60мм мөнгөн усны баганаас илүү буюу амьсгалын төвийг хүчтэй цочроох хэмжээнд хүрэх бөгөөд энэ үед амьсгал хөдөлгөөн огт үгүй байвал амьсгал эргэлтгүй зогссоны шинж гэж үзнэ.

4.3. ТҮТБ-ийн шийдвэрийн дагуу шаардлагатай тохиолдолд дараах шинжилгээнүүдийг хийнэ. Үүнд:

4.3.1. Тархины цахилгаан бичлэг;

4.3.2. Тархины судасны хэт авиан шинжилгээ;

4.3.3. Тархины судасны ангиографийн шинжилгээ.

4.4. Энэ журмын 4.3-т заасан шинжилгээг хийсэн тохиолдолд дүгнэлтийг өвчтөний цахим/цаасан өвчний түүхэнд хавсаргана.

**Тав. Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах эрх
бүхий нэгжийн үйл ажиллагааны зохицуулалт**

5.1. Зохицуулах алба нь донор эрүүл мэндийн байгууллага, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах багтай энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг хамтран зохион байгуулах эрүүл мэндийн байгууллагатай хийх гэрээ” байгуулан хамтран ажиллана.

5.2. Зохицуулах алба нь донор эрүүл мэндийн байгууллагаас тархины үхэлтэй боломжит донор илрүүлэлтийн мэдээллийг тогтмол авч байна.

5.3. Энэ журмын 3.16-д заасан мэдээллийг авсны дараа Нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэсэн тархины үхэлтэй боломжит донорын шинжилгээ, мэдээлэлтэй танилцана.

5.4. Зохицуулах албанаас тухайн донор эрүүл мэндийн байгууллагад очиж ажиллан, тархины үхэлтэй боломжит донорын мэдээлэлтэй танилцаж гэр бүлийн гишүүдтэй нь уулзалт зохион байгуулна.

5.5. Зохицуулах албанаас томилогдсон мэргэжилтэн нь гэр бүлд бодит байдал болон тархины үхлийн талаар мэдээллийг өгч, Донорын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус танилцуулж гэр бүлд донор болгох санал хүсэлт тавина.

5.6. Амьгүй буюу тархины үхэлтэй боломжит донорын гэр бүл зөвшөөрсөн тохиолдолд энэ тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан “Амьгүй донорын гэр бүлийн гишүүний зөвшөөрлийн хуудас”-ыг танилцуулан, боломжит донорын эхнэр, нөхөр, төрүүлсэн болон үрчилж авсан эцэг, эх, төрсөн хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, төрлийн хүн, садангийн хүн гэсэн дарааллаар гэр бүлийн 3 гишүүнээс эс, эд, эрхтэн тус бүрд зөвшөөрсөн эсэхийг бичүүлж, гарын үсэг зуруулж, 2 хувь үйлдэн баталгаажуулна.

5.7. Нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэгдсэн амьгүй донороос эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгуулах шаардлагатай иргэдийн хүлээх жагсаалтаас санал болгосон, тохирох реципиентийг Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэргэжлийн багтай хамтран хамтын хурлаар сонгож, хяналт тавина.

5.8. Зохицуулах алба донорын эс, эд, эрхтэн авах болон шилжүүлэн суулгах мэс засал хийлгүүлэхээр Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэргэжлийн багуудад бэлтгэл ажил хангахыг мэдэгдэнэ.

5.9. Зохицуулах алба нь амьгүй буюу тархины үхэлтэй донорыг эсвэл донорын эс, эд, эрхтнийг зөөвөрлөх тохиолдолд тээврийн хэрэгслийг эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эрүүл мэндийн байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

5.10. Энэ тушаалын зургаадугаар хавсралтаар баталсан “Тархины үхэлтэй донороос эс, эд, эрхтэн авсан болон хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл хөтлөх маягт”-

ийг Эс, эд, эрхтэн авсан баг тус бүр үйлдэн, цахим/цаасан өвчний түүхэнд хавсаргаж, хувийг зохицуулах албанд хадгална.

5.11. Энэ журмын 5.10-д заасан “Тархины үхэлтэй донороос эс, эд, эрхтэн авсан болон хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл хөтлөх маягт”-ыг гэр бүлд танилцуулан баталгаажуулна.

5.12. Амьд донор болсноос хойш 5 жилийн хугацаанд жилд нэг удаа рашаан сувилалд үнэ төлбөргүй сувилуулах иргэдийн дэлгэрэнгүй мэдээлэл (овог, нэр, регистрийн дугаар)-ийг жил бүрийн 1 дүгээр сарын 20, 4 дүгээр сарын 20, 7 дугаар сарын 20, 10 дугаар сарын 20-ний өдрийн дотор цахимаар болон албан бичгээр нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

5.13. Зохицуулах алба нь Эс, эд, эрхтэн авах мэс засал дууссаны дараа донорын цогцсыг цэгцлэх үйл ажиллагаанд бүхэлд нь хяналт тавина.

5.14. Зохицуулах алба, Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах багийн төлөөлөл хамтран цогцос түр хадгалах өрөөнд байрлуулж, цогцсыг цаашид хадгалах байгууллагын төлөөлөл болон гэр бүлд хүлээлгэн өгч энэ тушаалын есдүгээр хавсралтаар баталсан “Амьгүй донорын цогцсыг хүлээлгэн өгсөн тэмдэглэл” хөтлөн баталгаажуулна.

5.15. Зохицуулах алба нь амьгүй донорын гэр бүлд оршуулгын тэтгэмж олгоход шаардлагатай энэ тушаалын наймдугаар хавсралтаар баталсан “Амьгүй донор болсон тухай тодорхойлолт”-ыг үйлдэн гэр бүлд хүлээлгэн өгч баталгаажуулна.

5.16. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээтэй холбоотой иргэнээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шаардлагатай тохиолдолд тухайн Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах ёс зүйн хороотой хамтран шийдвэрлэнэ.

5.17. Амьгүй донорын эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгуулах шаардлагатай иргэдийн хүлээх жагсаалтыг эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах багуудаас ирсэн мэдээллийн дагуу бүртгэж, нэгтгэнэ.

5.18. Зохицуулах алба нь донор эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, үр дүнг нэгтгэн, жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Эрүүл мэндийн яаманд хүргүүлнэ.

5.19. Зохицуулах алба нь Донор эрүүл мэндийн байгууллага, Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эрх бүхий эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээ, үр дүн, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, уусмал, урвалжийн хангалт, бэлэн байдалд жилд нэг удаа хяналт, үнэлгээ хийж, тайланг Эрүүл мэндийн яаманд хүргүүлнэ.

5.20. Зохицуулах алба нь Донор эрүүл мэндийн байгууллагын болон Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах багийн эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд бусад байгууллагуудтай хамтран ажиллана.

5.21. Гадаад, дотоодын хурал, семинар, сургалтад оролцох, мэргэжлийн сэтгүүл, ном хэвлэлд судалгааны өгүүлэл, нийтлэл хэвлүүлэхэд Донор ба Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллана.

5.22. Донорын үйл хэргийг олон нийтэд таниулан ойлгуулах нөлөөллийн үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулна.

5.23. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг холбогдох хууль, журмын дагуу хадгална.

Зургаа. Амьгүй донороос эс, эд, эрхтэн авах багийн үйл ажиллагааны зохицуулалт

6.1. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эрх бүхий эрүүл мэндийн байгууллага нь амьгүй донороос эс, эд, эрхтэн авах баг, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах баг тус бүрийг томилон ажиллуулна.

6.2. Эс, эд, эрхтэн авах багийн бүрэлдэхүүнд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах багийн мэс заслын эмч, зохицуулагч, мэдээгүйжүүлэг судлалын эмч, эрчимт эмчилгээ судлалын эмч, лабораторийн эмч, эмгэг судлаач эмч, мэс заслын сувилагч, мэдээгүйжүүлгийн сувилагч, жолооч байна.

6.3. Эс, эд, эрхтэн авах багийг Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах багийн донорын мэс заслын эмч ахлан ажиллана.

6.4. Эс, эд, эрхтэн авах баг нь мэс засалд хэрэглэгдэх шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, эс, эд, эрхтэн тээвэрлэх зориулалтын сав, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангана.

6.5. Судсаар тэжээгдэх эс, эд, эрхтнийг тэжээгч болон тараагуур судас, түүний салаануудыг залгаас хийхэд хангалттай хэмжээгээр авч болохуйц мэс заслын хүрцийг сонгоно.

6.6. Эдийн шинжилгээгээр тархины үхэлтэй донорын эс, эд, эрхтэн нь эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний шаардлага хангаж байгаа нь батлагдсан даруйд Зохицуулах албанд мэдэгдэнэ. Эдийн шинжилгээг донор эрүүл мэндийн байгууллага эсвэл эрхтэн шилжүүлэн суулгах эрүүл мэндийн байгууллагад хийнэ.

6.7. Амьгүй буюу тархины үхэлтэй донороос Эс, эд, эрхтэн авах мэс засал эхлэхийн өмнө, мэс засал дууссаны дараа багийн гишүүд донорт хүндэтгэл үзүүлж, энэ журмын 5.14-д заасны дагуу ажиллана.

6.8. Эс, эд, эрхтэн авах багийн гишүүд мэс заслын талаарх дэлгэрэнгүй тэмдэглэлийг бичиж, авсан эс, эд, эрхтэн тус бүрийг энэ тушаалын зургаадугаар

хавсралтаар баталсан “Тархины үхэлтэй донороос эс, эд, эрхтэн авсан, хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл хөтлөх маягт”-д тэмдэглэж, зураг авч, дүрсжүүлэн тэмдэглэлд хавсаргаж, гарын үсэг зурж, баталгаажуулна. Мэс заслын үед хэвлийн ба цээжний хөндийд эмгэг өөрчлөлт байсан эсэхийг тэмдэглэлд дэлгэрэнгүй бичнэ.

6.9. Амьгүй донороос эс, эд, эрхтэн авах мэс заслыг донор эрүүл мэндийн байгууллагад хийх боломжгүй тохиолдолд энэ журмын 8.1 дэх заалтыг баримтлан ажиллана.

6.10. Амьгүй донороос эс, эд, эрхтнийг авахдаа дараах дарааллыг баримтлан ажиллана.

6.10.1. Зүрх, уушгины баг цээжний хөндийг нээж эрхтэн чөлөөлнө.

6.10.2. Элэгний баг хэвлийн хөндийг нээж эрхтнийг чөлөөлнө.

6.10.3. Нойр булчирхай, бөөрний баг эрхтнийг чөлөөлнө.

6.10.4. Цээж, хэвлийн эрхтнийг угаана.

6.10.5. Эс, эд, эрхтнийг авахдаа зүрх, уушги, элэг, нойр булчирхай, бөөр, судас, шөрмөс болон бэхлэгдсэн ясны хэсэг, арьсны хэсэг, нүдний эвэрлэг гэсэн дарааллаар авна.

6.11. Донорын эс, эд, эрхтнийг тусгай зориулалтын саванд хийж, энэхүү журмын 8.4-д заасан хугацаанд багтааж, боломжит богино хугацаанд тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын өрөөнд хүргэж, хүлээлгэж өгнө.

6.12. Эс, эд, эрхтэн авах мэс засал дууссаны дараа багийн гишүүд авсан эс, эд, эрхтнийг хиймэл бэлдцээр орлуулан, цогцсыг цэгцлэн хааж, энэ журмын 5.14 болон 6.7 дугаар заалтын дагуу ажиллана.

6.13. Тархины үхэлтэй донороос эс, эд, эрхтэн авахад дараах заалтыг баримтална. Үүнд:

Шалгуур	Эрхтэн тогтолцоо			
	Бөөр	Элэг	Зүрх	Нойр булчирхай
Насны хязгаар	75-аас доош байх	75-аас доош байх	75-аас доош байх	75-аас доош байх
Эсрэг заалт	- Бөөрний архаг өвчин - Бөөр уйланхайжих өвчин - АД ихсэх өвчин - Бөөрний гэмтлийн асуумж - Чихрийн шижин	- Элэгний вирусийн шалтгаант архаг өвчин - Хордсон тохиолдолд - Элэгний эд эс гэмтээх эмээр хордсон тохиолдолд	- Зүрх судасны архаг өвчин - Цээжний гэмтлийн үед зүрх гэмтсэн - Зүрх зогссон	- Чихрийн шижин - Нойр булчирхайн архаг үрэвсэл - Хэвлийн хөндийн гэмтэл - Хэвлийн хөндийн идээт үрэвсэл

		- 7 хоногоос илүү хугацаанд зохиомол амьсгалын аппараттай байсан эсэх - Эрхтэн авахаас өмнө зүрх зогссон тохиолдолд - Элэгний өөхжилт 50%-иас дээш байх		- Архаг архидалт - Таргалалт - Нойр булчирхайн өөхлөлт
Авах шинжилгээ	▪ШЕШ ▪Шээсний ариун чанар ▪Биохими ▪Цус бүлэгнэлт ▪Хэт авиа ▪Бөөрний эдийн шинжилгээ	▪HBV, HCV маркер ▪Биохими ▪Цус бүлэгнэлт ▪Хэт авиа ▪Элэгний эдийн шинжилгээ	▪ЭКГ ▪Зүрхний хэт авиа ▪Цээжний рентген зураг ▪Биохими (Зүрхний шигдээсийн маркер - тропонин, С урвалжит уураг заавал) ▪Цус бүлэгнэлт	▪ЭКГ ▪Биохими (Глюкоз, амилаза заавал үзэх) ▪ШЕШ ▪Цус бүлэгнэлт ▪Хэт авиа
Тохироо	▪Цусны ABO бүлэг ▪Резус фактор ▪Хүний цагаан эсийн антиген, ▪Цагаан цогцсын солбилцох урвал	▪Цусны ABO бүлэг ▪Резус фактор ▪Суулгац элэгний эзлэхүүн ▪Цагаан цогцсын солбилцох урвал	▪Цусны ABO бүлэг ▪Резус фактор ▪Хүний цагаан эсийн антиген ▪Цагаан цогцсын солбилцох урвал	▪Цусны ABO бүлэг ▪Резус фактор ▪Хүний цагаан эсийн антиген ▪Цагаан цогцсын солбилцох урвал

6.14. Эс, эд, эрхтнийг холбогдох эмнэлзүйн зааврын дагуу авах явцдаа ойр орчмын эс, эд, эрхтний бүрэн бүтэн байдлыг хадгалж хамгаалах, цогцост хүндэтгэлтэй хандах зарчмыг баримтална.

6.15. Эс, эд, эрхтэн авах мэс засалд зарцуулсан эм, хэрэгсэл, эд материалын хэрэглэсэн тоо ширхэг, хэмжээг оролцсон баг тус бүр гаргаж, хагас, бүтэн жилийн тайланг зохицуулах албанд хүргүүлнэ.

Долоо. Осол, гэмтлийн улмаас тархины үхэлд хүрсэн донор гарсан тохиолдолд хийх нэмэлт үйл ажиллагаа

7.1. Осол, гэмтлийн улмаас хүнд гэмтэл авсан үйлчлүүлэгчийг хүлээж авсан эрүүл мэндийн байгууллага нь зохих стандарт, эмнэл зүйн удирдамжийн дагуу сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээг заавал хийнэ.

7.2. Хууль хяналтын байгууллага (цагдаа)-д хандана. Хууль хяналтын байгууллагын ажилтанд анхны үзлэг хийх боломжийг бүрдүүлнэ. Анхны үзлэгийн дүгнэлт гаргуулж тэмдэглэл хөтөлнө.

7.3. Осол гэмтлийн зэргийг тогтоох, шаардлагатай оношилгоог боломжит нөхцөлд тулгуурлан хийнэ.

7.4. Зохицуулах алба, хууль хяналтын байгууллагын төлөөлөл Амьгүй буюу тархины үхэлтэй донороос эс, эд, эрхтэн авах мэс заслын үйл ажиллагаанд хяналт тавьж энэ тушаалын аравдугаар хавсралтаар баталсан “Осол, гэмтлийн улмаас тархины үхэлд хүрсэн амьгүй донороос эс, эд, эрхтэн авсан, хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл хөтлөх маягт”-ыг үйлдэж, зураг авч, дүрсжүүлэн тэмдэглэлд хавсаргаж, гарын үсэг зурж, баталгаажуулна.

7.5. Задлан шинжилгээний үеийн явцыг дүрсжүүлэн баталгаажуулна.

7.6. Нэмэлт задлан шинжилгээ хийгдсэн тохиолдолд цогцсыг задлан шинжилгээ дууссаны дараа Зохицуулах алба, эмгэг судлал эсвэл шүүх шинжилгээний байгууллага хамтран цогцос түр хадгалах өрөөнд гэр бүлд хүндэтгэлтэй хүлээлгэн өгч тэмдэглэл хөтлөн баталгаажуулна.

Найм. Донор болон донорын эс, эд, эрхтнийг хадгалах, тээвэрлэх

8.1. Амьгүй донорыг тээвэрлэх шаардлагатай тохиолдолд тусгай зориулалтын түргэн тусламжийн тээврийн хэрэгслээр эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эрүүл мэндийн байгууллага руу тээвэрлэх үйл ажиллагааг мэдээгүйжүүлэг судлалын эмч, эрчимт эмчилгээ судлалын эмч ахалж Зохицуулах алба хяналт тавьж ажиллана.

8.2. Тээвэрлэх үед амин чухал эрхтнүүдийн үйл ажиллагааг дэмжих эрчимт эмчилгээг заавар, стандартын дагуу хийнэ.

8.3. Шилжүүлэн суулгах эс, эд, эрхтнийг авсан даруйд зориулалтын уусмалд хадгалан, эс, эд, эрхтэн зөөвөрлөх мөстэй ариун саванд хийж зориулалтын түргэн тусламжийн тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

8.4. Зүрх, элэг, нойр булчирхайг 4-8 цаг, бөөрийг 12 цаг, нүдний эвэрлэгийг 3-14 хоног, судас, шөрмөс, ясны хэсгийг 2 жил, зүрхний хавхалгыг 5 жил хүртэл хугацаагаар тус тус хадгалж болно.

8.5. Эс, эд, эрхтнийг тээвэрлэхэд энэхүү журмын 6.8-д заасан тэмдэглэлийг хавсаргана.

8.6. Эс, эд, эрхтэн авсан багийн ахлагч тээвэрлэхийн өмнө эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.

8.7. Донор эрүүл мэндийн байгууллагад амьгүй донороос эс, эд, эрхтэн авах мэс засал хийх боломжгүй тохиолдолд тээвэрлэнэ.

8.8. Амьгүй донорыг тээвэрлэх асуудлыг донор эрүүл мэндийн байгууллага, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эрүүл мэндийн байгууллага, Зохицуулах алба хамтран зохион байгуулна.

Ес. Донорын эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах эрүүл мэндийн байгууллагад тавигдах нийтлэг шаардлага

9.1. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг тусгай зөвшөөрөл бүхий магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн баг хийж гүйцэтгэнэ.

9.2. Мэргэжлийн багт дараах шаардлага тавигдана. Үүнд:

9.2.1. Мэргэжлийн багт мэс заслын эмч, мэдээгүйжүүлэг судлалын эмч, судасны мэс заслын эмч, эрчимт эмчилгээ судлалын эмч, элэг/бөөр шилжүүлэн суулгасны дараах хяналтын эмч, хоол боловсруулах тогтолцоо судлалын эмч, бөөр судлалын эмч, зүрх судлалын эмч, нүд судлалын эмч, эмнэлзүйн эмгэг судлалын эмч, хүүхэд судлалын эмч, хавдар судлалын эмч, халдварт өвчин судлалын эмч, ангиографи/судсан дотуурх оношилгоо, эмчилгээ судлалын эмч, эмнэл зүйн хоол эмчилгээ судлалын эмч нар багтана.

9.2.2. Мэргэжлийн баг нь батлагдсан заавар, стандартыг дагаж мөрдөнө;

9.2.3. Мэс засал, мэдээгүйжүүлэг, оношилгоо, лабораторийн орчин үеийн багаж, тоног төхөөрөмжтэй байна;

9.2.4. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийх бололцоо бүхий бүрэн тоноглогдсон вакуумжсан 2 өрөө, судасны мэс заслын болон эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын иж бүрдэл, механик шарх тэлэгч, микроскоптой мэдээгүйжүүлгийн иж бүрдэл, хяналтын мониторуудтай байна;

9.2.5. Нам болон өндөр даралтын ариутгалын хэсэгтэй байна;

9.2.6. Шилжүүлэн суулгах мэс заслын дараах бүрэн тоноглогдсон эрчимт эмчилгээний тусгаарлагдсан өрөөтэй байна;

9.2.7. Реципиентийн хяналтын тусламж, үйлчилгээ үзүүлдэг байна;

9.2.8. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эрүүл мэндийн байгууллага нь мэргэжлийн багийн тасралтгүй үйл ажиллагааны бэлэн байдлыг ханган ажиллана;

9.2.9. Мэргэжлийн багийн гишүүн нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

9.2.9.1. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах чиглэлээр гадаад улс оронд 3-аас доошгүй сар, дотоодод 6 сараас 1 жилийн хугацаатай тус тус тухайн мэргэшлээрээ дагнан суралцаж, дадлагажсан, гэрчилгээтэй байна;

9.2.9.2. Эзэмшсэн мэргэшлээрээ 5 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай байна;

9.2.9.3. Ёс зүйн зөрчил болон мэргэжлийн алдаа гаргаагүй байна;

9.2.9.4. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний талаарх сургалтад жил бүр хамрагддаг байна.

Арав. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны зохицуулалт

10.1. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эрүүл мэндийн байгууллага нь тархины үхэлтэй донор илрүүлсэн талаарх мэдээллийг Зохицуулах албанаас авснаас хойш эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах бэлтгэл ажлыг хангана.

10.2. Амьд донороос эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг төлөвлөхөөс өмнө донор, реципиентийн гэр бүлийн хамаарлыг нотолсон баримт бичиг, холбогдох материалыг бүрдүүлэн, Зохицуулах албанаас тодорхойлолт авсан байна.

10.3. Амьд донороос эс, эд, эрхтэн авахын өмнө энэ тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Амьд донорын зөвшөөрлийн хуудас”-ыг бөглүүлэн, гарын үсэг зуруулан баталгаажуулна.

10.4 Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний өмнө цусны бүлэг тодорхойлох, эд нийцлийн тохирооны шинжилгээг хийж, реципиентэд тохирох эсэхийг шийднэ.

10.5. Реципиентэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын өмнө энэ тушаалын долоодугаар хавсралтаар баталсан “Реципиентийн зөвшөөрлийн хуудас”-ыг бөглүүлэн, гарын үсэг зуруулан баталгаажуулна.

10.6. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгасан талаарх холбогдох мэдээллийг тухай бүр Нэгдсэн бүртгэл мэдээллийн санд багийн зохицуулагч оруулна.

10.7. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын үед реципиентийн мэс засалд шаардагдах цус, цусан бүтээгдэхүүний захиалгыг хийж, цусны банкны нөөцийг бүрдүүлнэ.

10.8. Донорын эс, эд, эрхтэн авах үйл ажиллагаатай уялдуулан реципиентийн мэс заслыг яаралтай бэлтгэж, эхлүүлнэ.

10.9. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг стандарт, батлагдсан заавар, стандарт, удирдамжийн дагуу хийж гүйцэтгэнэ.

10.10. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын явцыг өвчний түүхэнд тодорхой бичиж, зурж тэмдэглэн гарын үсэг зурж баталгаажуулна.

10.11. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээний дараах эхний 1 сар мэс заслын эмч, тухайн эрхтэн шилжүүлэн суулгасны дараах хяналтын эмчтэй хамтран хянаана.

10.12. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний дараах реципиентийн эмчилгээ, шинжилгээ, биеийн байдлыг тухайн тасгийн эрхлэгч, зөвлөх, эмчлэгч эмч болон эрхтэн шилжүүлэн суулгах баг хамтран хянаана.

10.13. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний явц, түүний дараах хяналтын талаарх мэдээллийг Нэгдсэн бүртгэл мэдээллийн санд оруулна.

10.14. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгасан талаарх санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мэдээг хагас, бүтэн жилээр гарган Зохицуулах албанд ирүүлнэ.

10.15. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын дараа тухай бүр ажлын 5 хоногоос хэтрүүлэлгүй дараах бичиг баримтыг Зохицуулах албанд хүргүүлнэ. Үүнд:

10.15.1. Энэ тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Амьд донорын зөвшөөрлийн хуудас”,

10.15.2. Энэ тушаалын долоодугаар хавсралтаар баталсан “Реципиентийн зөвшөөрлийн хуудас”,

10.15.3. Амьд донор болон реципиентийн иргэний үнэмлэхийн хуулбар,

10.15.4. Реципиенттэй байгуулсан гэрээ.

10.16. Амьгүй донороос эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгуулах шаардлагатай иргэдийн хүлээх жагсаалтад бүртгүүлэх иргэний холбогдох материалыг Зохицуулах албанд тухай бүр хүргүүлнэ.

Арван нэг. Шаардлага хангаагүй эс, эд, эрхтнийг устгах

11.1. Бэлтгэх, тээвэрлэх, хадгалах, суулгах горим алдагдсан эс, эд, эрхтэн болон уг үйл ажиллагаанд хэрэглэсэн нэг удаагийн багаж хэрэгслийг хамтад нь устгахдаа холбогдох дүрэм, журмыг баримталж ажиллана.

11.2. Эс, эд, эрхтнийг хэсэгчлэн хэрчиж, бүтцийн бүрэн бүтэн байдлыг эвдэн, эс, эд, эрхтэн шаардлага хангахгүй тухай тэмдэглэл үйлдэн, эрхтэн авах багийн ахлагч тэмдэглэлийг Эмгэг судлалын үндэсний төвд хүлээлгэн өгнө.

11.3. Эмгэг судлалын үндэсний төв нь шаардлага хангахгүй эс, эд, эрхтнийг устгаж, тэмдэглэл хөтөлнө.

Арван хоёр. Хариуцлага

12.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
... сарын ... өдрийн ... дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

БАТЛАВ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ

БАТЛАВ.

ДОНОР ЭРҮҮЛ
МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫН
ЗАХИРАЛ/ДАРГА

БАТЛАВ.

ЭС, ЭД, ЭРХТЭН
ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫН
ЗАХИРАЛ/ДАРГА

**ЭС, ЭД, ЭРХТНИЙГ ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ
ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

... оны ...-р сарын ... -ны өдөр

№ ...

Улаанбаатар хот

